

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2 Уурхайн ашиглалтын төлөвлөгөө, хүчин чадал	3
1.2.1 Ил уурхайн ажиллах горим	4
1.2.2 Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүд	6
1.2.3 Далд уурхайн ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүд	6
1.3 Дэд бүтэц	8
1.3.1 Уурхайн барилга байгууламж	8
1.3.2 Цахилгаан хангамж	8
1.3.3 Усан хангамж	8
1.4 Эдийн засгийн үзүүлэлт:	10
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	11
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	14
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /2025 ОН/	16
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18
4.2 Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө	21
4.3 Тэрбум мод тарих арга хэмжээний төлөвлөгөө	21
4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	21
4.5 Түүх, соёлыг өвийг хамгаалах төлөвлөгөө	21
4.6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
4.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	23
4.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	24
4.9 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	25
4.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	28
4.11 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	29

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилбол	3
Хүснэгт 2. Ашиглалтын төлөвлөгөө хүчин чадал хэмжээ	5
Хүснэгт 3. Тоног төхөөрөмжийн нэгдсэн жагсаалт	5
Хүснэгт 4. Хуулах шимт хөрсний хэмжээ	6
Хүснэгт 5. Уулын ажлын хэмжээ	6
Хүснэгт 6. Далд уурхайн уулын ажлын горим	7
Хүснэгт 7. Барилга, байгууламжийн жагсаалт	8
Хүснэгт 8. Усан хангамжийн ерөнхий мэдээлэл	9
Хүснэгт 9. Нийт ус хэрэглээний тооцоо	9
Хүснэгт 10. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврын чанарын үнэлгээ	14
Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал /2025 он/	17
Хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18
Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
Хүснэгт 14. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	23
Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	24
Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26
Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө	28
Хүснэгт 18. БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө	29

1.2 Уурхайн ашиглалтын төлөвлөгөө, хүчин чадал


Уурхайн ашиглалт гүнзгийрэх үед ашиглалтын 1 дахь жилээс эхлэн хөрс хуулалт болон хүдэр олборлолтын ажлыг урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлт хийсний дараа экскаватороор хутган автосамосвалд ачиж, хөрс хуулалтын чулуулгийг ил уурхайн гадаад овоолгод, хүдрийг хүдрийн овоолго хүртэл тээвэрлэн байршуулна.

1.2.1 Ил уурхайн ажиллах горим

Төсөлд ил уурхай геологийн бодитой ба боломжтой (В+С) зэргийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В' нөөцөд шилжүүлэн тооцсоноор үйлдвэрлэлийн нийт 24.6 мян.тн хүдэр, хүдэр дэх эрдсийн хэмжээ 7.8 мян.тн байна. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 46.4 мян.м³ хөрс хуулалт хийж ил уурхай жилд 25.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар 1 жилийн хугацаанд ажиллахаар төлөвлөсөн.

Мөн далд уурхай геологийн бодитой ба боломжтой (В+С) зэргийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В' нөөцөд шилжүүлэн тооцсоноор үйлдвэрлэлийн нийт 114.6 мян.тн хүдэр, хүдэр дэх эрдсийн хэмжээ 40.9 мян.тн байна. Жилд 45.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар 3 жилийн хугацаанд ажиллахаар төлөвлөсөн.

Ил уурхайн ашиглалтын систем нь авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын систем, далд уурхайн ашиглалтын систем нь цооногийн цэнэгийн аргаар нураах ашиглалтын системээр тус тус ашиглана.



Зураг 2. Уурхайн ерөнхий дэвсгэр зураг

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨРГӨНИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ
10-Р ХҮДРИЙН БҮСИЙН ХЭСГИЙГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Өргөн” хайлуур жоншны ордыг ил уурхайн болон далд аргаар ашиглана. Ашиглалтын жил бүр ангилан ялгах цехэд нийлүүлэх хүдрийн хэмжээ болон дундаж агуулгыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Ашиглалтын төлөвлөгөө хүчин чадал хэмжээ

Ашиглалтын жил	Ашиглалтын нөөц		
	Хүдэр	CaF2 агуулга	Эрдэс
	тн	%	тн
I-р жил	47966.9	34.20	15720.4
II-р жил	45601.2	35.60	16234.0
III-р жил	45601.2	36.51	16650.0
Нийт	139169.2	34.92	48604.4

Ангилан ялгах цехийн хүчин чадлыг төсөл захиалагчаас ирүүлсэн техникийн даалгаварт санал болгосны дагуу болон уулын ажлын хүчин чадалтай уялдуулж мөн эхний жилд 48.0 мян.тн хүдэр, ашиглалтын 2-3 дах жилд 45.6 мян.тн хүдэр ангилан ялгах аргаар төлөвлөлөө. “Лотус-Амгалан” ХХК-ийн “Өргөн” хайлуур жоншны ангилан ялгах цех нь улирлын чанартай ажиллах бөгөөд жилд дунджаар 307 хоног ажиллана. Ангилан ялгах цех нь хоногт 10 цагийн 1 ээлжээр ажиллана.

Баяжуулалтын технологи: Ил болон уурхайгаас нийлүүлэгдэх хүдрийг (< 350мм) хацарт бутлуураар dmax 100 мм хүртэл бутлан, бутлагдсан хүдрийг чичиргээт шигшүүрээр шигшин шигшүүрийн доод бүтээгдэхүүнийг буюу -20 мм ангиллын фракцыг нарийн ширхэглэлтэй хүдрийн овоолгод зөөвөрлөн хураана. Шигшүүрийн дээд +20 ангиллын бүтээгдэхүүнийг гар ялгалт хийн ФК-85 болон ФК-75 маркийн баяжмал гарган авах ба хаягдлыг овоолгод хураана.

Ордыг ашиглалтын гар ялгалтын хаягдал болон шигшүүрийн -20 мм-ийн ангиллын бүтээгдэхүүнийг эдийн засгийн хувьд ашигтайгаар баяжуулах боломжийн буюу сүүлийн үед БНХАУ-д нэвтрээд буй лазер аргын, гравитацийн аргаар баяжуулах судалгааг хийж гүйцэтгэнэ. Мөн тухайн ордтой ойр байрлах болон шинээр байгуулагдах флотацийн болон шинэ технологийн үйлдвэрүүдэд нийлүүлэх судалгааг хийнэ.

Тоног төхөөрөмжүүд: “Лотус-Амгалан” ХХК нь хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэрт тоног төхөөрөмжийн сэлбэг, материалын олдоц мөн нийлүүлэлт зэргийг харгалзан үзэж БНХАУ-д үйлдвэрлэсэн тоног төхөөрөмжүүдийг сонгон суурилуулсан байна. Хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэр нь жилийн хүчин чадал 48.0 мян.тн байна. Хүдэр бэлтгэх хэсэг нь 1 шатны бутлалт, 1 шатны шигшилтээс бүрдэнэ. Баяжуулах үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжүүд нь хацарт бутлуур, шигшүүр, туузан конвейер зэрэг төхөөрөмжүүд байна.

Хүснэгт 3. Тоног төхөөрөмжийн нэгдсэн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Тоо, ш	Хөдөлгүүрийн чадал, кВт	Нийт чадал, кВт
1	Хүдэр хүлээн авах бункер		1	0	0
2	Чичиргээт тэжээгүүр	ZSW3090	1	11	11
3	Хацарт бутлуур	PE400x600	1	30	30

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨРГӨНИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ
10-Р ХҮДРИЙН БҮСИЙН ХЭСГИЙГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

4	Чичиргээт шигшүүр	2YA1548	1	15	15
5	Туузан конвейер	500-1000	5	5.5	27.5
	Нийт		9	61.5	83.5

1.2.2 Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүд

Ашиглалтын явцад уулын ажил явагдахаар төлөвлөгдсөн талбайн өнгөн хөрсийг Монгол улсад дагаж мөрддөг шаардлага стандартын дагуу 0.3 м зузаантайгаар урьдчилан хуулна. Хуулж бэлтгэсэн шимт хөрс нь ордын ашиглалтын явцад болон ордыг ашиглаж дууссаны дараах нөхөн сэргээлтийн ажилд ашиглагдах юм. Шимт хөрсний овоолгын өндөр нь 3 м байх бөгөөд хажуугийн тогтворжилтын өнцөг нь 25-33 градус байна. Шимт хөрсийг хуурай сэрүүний улиралд хуулах нь тохиромжтой бөгөөд овоолгыг аль болох нөмөр газар хийх ба тийм боломжгүй тохиолдолд шимт хөрсний овоолгыг сууж дагтарштал нь тусгай зориулалтын торон хучилт хийж салхи шуурганд хийсэхээс сэргийлэх болон ургамалжуулж болно. Шимт хөрсийг уурхайн үндсэн хөрс хуулалтын ажлаас өмнө хуулж овоолсон байна.

Хүснэгт 4. Хуулах шимт хөрсний хэмжээ

Уурхай, м ²	Овоолго, м ²	Бусад 10%	Нийт эвдрэлд өртөх талбай, м ²	Хуулах шимт хөрсний хэмжээ, м ³
6,500.0	17,000.0	4,700.0	28,200.0	8,460.0

Хүснэгт 5. Уулын ажлын хэмжээ

Ашиглалт-тын жил	Ил уурхай							
	Хүдэр		Агуулга %		Нөөц, тн		Хөрс хуулалт	Кхх
	м ³	тн	CaF ₂	CaCO ₃	CaF ₂	CaCO ₃	м ³	тн/м ³
1-р жил	9,525.25	24,567.34	31.81	5.60	7,814.38	1,376.93	46,401.00	1.89

Тээвэрлэлт: ТЭЗҮ боловсруулах техникийн даалгавар болон уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу эхний жилд ил аргаар ашиглах бөгөөд 92.5 мян.м³ уулын цул тээвэрлэнэ.

1.2.3 Далд уурхайн ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүд

Хүдрийн биетийн зузаан тогтворгүй 5 м–ээс 55,1 м хүрнэ. Иймд 1-р хүдрийн биетийн тогтоц, гадаргууд ил гаршгүй нөхцөл зэргийг харгалзан далд аргаар олборлохоор төлөвлөгдсөн.


Далд уурхайн ажиллах горим: Тус уурхай нь жилийн турш тасралтгүй горимоор ажиллана. Ээлжийн үргэлжлэх хугацааг хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу гүний уурхайн ажилчдад 7 цагаар, газрын дээрх ажилчдад 8 цагаар ажиллана.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨРГӨНИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ
10-Р ХҮДРИЙН БҮСИЙН ХЭСГИЙГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 6. Далд уурхайн уулын ажлын горим

Ажлын горим	Тоо	Нэгж
Хуанлийн хоногийн тоо	365	хоног
Баяр ёслол, цаг агаарын саатал, сул зогсолт	65	хоног
Жилд ажиллах өдрийн тоо	300	хоног
Ээлжийн үргэлжлэх нийт хугацаа / Газрын дээр /	8	цаг
Ээлжийн үргэлжлэх нийт хугацаа / Газрын доор /	7	цаг
Хоногт ажиллах ээлжийн тоо / Газрын дээр /	2	ээлж
Хоногт ажиллах ээлжийн тоо / Газрын доор /	2	ээлж

Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг, тоног төхөөрөмж угсарч монтажлах ажлуудыг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ.



Зураг 3. Далд уурхайн план зураг

Ашиглалтанд хүлээн авснаас хойш эхний жил II, III түвшингүүдэд хийгдэх үндсэн ба бэлтгэл малталтуудыг бүрэн хийсэн байна. Ашиглалтын 2 дахь жилд III-IV түвшинд хийгдэх үндсэн ба бэлтгэл малталтуудыг бүрэн хийсэн байна.

Дэд давхараар ашиглах ашиглалтын систем хэрэглэх үед тээврийн штрекээс орт нэвтэрч болкийн восстающийнуудаас бие биенээсээ 6-8 м өндөрт дэд давхаргын штрек нэвтэрч босоо чиглэлд дэвүүр хэлбэрийн цооногууд өрөмдөж нураана.

Хээрийн тээврийн штрекээс орт нэвтэрч бие биенээсээ 6-8 м өндөрт дэд давхаргын штрек нэвтэрч босоо чиглэлд дэвүүр хэлбэрийн цооногууд өрөмдөж нураана. Тээврийн штрекний түвшинд хүдэр дундуур нэвтэрсэн огтолгооны малталтыг өрмийн штрек гэж нэрлэх ба хөндлөн огтлолын талбай нь дэд давхарын штректэй ижил байна.



Зураг 4. Төсөл хэрэгжих талбайн ерөнхий зураг

1.3 Дэд бүтэц

1.3.1 Уурхайн барилга байгууламж

Уурхайн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр, агуулах-засварын байр багтана.

Хүснэгт 7. Барилга, байгууламжийн жагсаалт

№	Нэр	Хийц, бүрдэл	Тоо, ш
1	Засвар механикийн хэсэг	Сэндвич	150 м ²
2	Автограж	Сэндвич	100 м ²
3	Сэлбэг, материалын агуулах	Сэндвич	50 м ²
4	Түлшний агуулах	ёмкость	60м ³
5	Тэсэлгээний материалын агуулах	контейнер	40 тн
6	Харуул хамгаалалтын байр	Сэндвич	20 м ²
7	Оффис	Сэндвич	150 м ²
8	Амрах байр	Сэндвич	200 м ²
9	Амралтын байр	Сэндвич	100 м ²
10	Гал тогоо	Сэндвич	150 м ²

1.3.2 Цахилгаан хангамж

Уурхайн хувьд цахилгаан хэрэглээг Өргөн сумын төвийн 10 кВ ЦДАШ-аас салаалан 0.4кВ-ын цахилгаан эрчим хүчээр тэжээх 1000/10/0.4 кВ-ын нэг хүчний трансформатор бүхий 1000 кВА-н трансформатораас тэжээнэ.

1.3.3 Усан хангамж


Ус хангамжийн эх үүсвэр:

Уурхайн ажилчдын унд ахуйн усны хэрэглээ, зам талбайн усалгаа, ногоон байгууламжийн усалгаанд ашиглагдах усыг өөрийн эзэмшлийн гүний худгаас хангахаар төлөвлөсөн байна.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨРГӨНИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ
10-Р ХҮДРИЙН БҮСИЙН ХЭСГИЙГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 8. Усан хангамжийн ерөнхий мэдээлэл

Эзэмшигч байгууллага	“Лотус амгалан” ХХК
Худаг гаргасан байгууллага	“Панголин дриллинг” ХХК
Худгийн байршлын солбилцол	47° 55' 51.762" 47° 55' 51.762"
Цооногийн гүн	82 м
Усны ундарга	2.2 л/с



Зураг 5. Гүний худгийн байршлын зураг

Ус хэрэглээний тооцоо

Хүснэгт 9. Нийт ус хэрэглээний тооцоо

№	Ус ашиглалтын хэлбэр	Усны эх үүсвэр	Ашиглах усны хэмжээ		
			Нэг хоногт хэрэглэх усны хэмжээ	Нэг жилд хэрэглэх усны хэмжээ	3 жилд хэрэглэх усны хэмжээ
1	Ажилчдын унд ахуйн усны хэрэглээ	гүний худаг	13.05	3915	10049
2	Зам усалгаа, тоос дарах		10	240	720
3	Ногоон байгууламж хийх усалгаа		56.4	1354	3274
Нийт			79.45	5509	14042

1.3 Эдийн засгийн үзүүлэлт

Уг төслийг хэрэгжүүлснээр 87 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 3.24 сая.төг байхаар байна.

Төсөл хэрэгжүүлэхэд нийт 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс далд уурхайн хөрөнгө оруулалт 897.8 сая төгрөг, баяжуулах үйлдвэрийн хөрөнгө оруулалт 96.5 сая төгрөг, гадаад тээвэр 202.0 сая төгрөг, захиргаа аж ахуйн хэсэгт 390.0, автозамын ажилд 100 сая төгрөг, эргэлтийн хөрөнгөд 150.0 сая төгрөг байхаар тус тус тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардалд жилд 434.46 сая төгрөг байхаар тооцоолсон байна.

Уурхайг ашиглах хугацаанд нийт 21.69 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл үйл ажиллагааны зардал гарган, 30.41 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 8.72 тэрбум төгрөгийн татварын өмнөх, татвар ногдуулсны дараах байдлаар нийт 7.85 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 6.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд 1 тн хайлуур жоншны баяжмал үйлдвэрлэх бүрэн өөрийн өртөг 155.88 мян.төг/тн байна.

Төсөл хэрэгжих хугацаанд нийт 9.15 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV, @10%) 4'697.3 сая төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 86.3%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 1.08 жил байхаар тооцжээ.

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүйн нөхцөл: Дорноговь аймаг нь Монголын зүүн өмнөд хэсгийн талархаг гадаргатай хэсэгт оршдог. Гэхдээ энд Хутаг уул (1431м), Оцол, Сансар, Их Багадулаан, Аргалант, Хан Баянзүрх хайрхан (1031м) зэрэг уулууд бий, Нутгийн дундуур зүүн хойшоо баруун урагшаа их хотгор газар үргэлжилнэ.

Дорноговь аймгийн нутагт том гол мөрөн, нуур байхгүй, харин газар доорх усны их нөөц бий. Халзан уул, Бусийн Чулууны, Толь булгийн зэрэг рашаан устай. Нутгийн ихэнхэд говийн бор хөрс тархсан бөгөөд элс нилээд байдаг.

Уурхайн орчмын газрын гадаргуу нь хойноосоо урагшаа намссан ухаа гүвээт гадаргатай. Судалгаанд хамрагдсан талбайн гадаргын үнэмлэхүй өндөр далайн түвшнээс дээш + 960, + 1080 м-ийн хооронд хэлбэлзэнэ. Толгодын хөндийд салхиар хуримтлагдсан 0.15-0.30 м заримдаа хэд хэдэн метр өндөр элсэн довцогууд тохиолдоно. Ордын чулуулгийн тогтоц, илэрцийн байдал дунд зэрэг. Хадан илэрц нь ихэвчлэн толгод нам уулсын оройн хэсгээр, бага хэмжээгээр тэдгээрийн хажуу хормойгоор тархсан байна.

Тухайн талбайн орчны хэв шинж нь далайн түвшнээс дээш 1007-1022 метрт өргөгдсөн жижиг гүвээлэг, гадаргуу зонхилох ба жижиг толгодлог гадаргуу нь алсаас налуу тэгш тал газрын байдалд аажмаар шилжсэн байна. Тэгш тал гадаргуутай хэсгүүд нь цэрдийн хотгоруудтай орон зайн хувьд давхцах ба үнэмлэхүй өндөржилт нь дунджаар 1022 м, харьцангуй өндөржилт нь 10-50-т хэлбэлзэнэ. Шорвог устай жижиг нуурууд, түүний хуурай ай савууд, хужирлаг цайдам, хөндий бүхий хотгоруудын хаяа хязгаар нь алсуур налуу, сулхан хэрчигдэлтэй оршдог. Ер нь хотгор гүдгэрийн нийт төрх байдалаараа Алтайн ар, өвөр говь болон монголын Дорнод хэсгийн өндөрлөг тал хоёрын хоорондох завсарын шинжтэй гэж болохоор юм. Төслийн талбай нь газрын гадаргын өндөржилтийн хувьд 811-939 м/д.т.д/-т байрлаж байна.


Хөрс, хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих талбайд Монгол орон газарзүйн байршлын хувьд Дорнод Сибирийн цэвдэгт тайгаас Төв Азийн хуурай цөлд шилжих завсрын нутгийг эзлэх тул байгалийн нөхцөлийн ялгаа маш эрс тэс, нөгөө талаар гадаргын төрх байдал жигд биш өндөр нам уул нуруу, хотос хонхор, ухаа гүвээ, хяр толгод, хөндий хоолой, нүд алдам тал газар хосолсон учраас хөрсөн бүрхэвчийн бүтэц, бүрэлдэхүүн ихээхэн ярвигтай, олон янзын өв өрмөц маягийн хөрс үүсэж, хөгжих нөхцөл бүрджээ. Төсөл хэрэгжих талбайд хээржүү цөлийн бор хөрсний хэв шинж тархаж байна.

Хөрс бий болох үйл явц нь хөрсний өнгөн давхарга дахь биологийн үйл явц зэргээр тодорхойлогдоно. Хөрсний өнгөн давхаргын жилийн дундаж температур +8.8°C байдаг ба зөвхөн өвлийн саруудад тэг градусаас доошилдог байна.

Хөрсний хөлдөлт ихэвчлэн арван нэгдүгээр сараас гуравдугаар сарын хооронд болдог байна. Хөрсний улирлын хөлдөлтийн дундаж гүн, хугацаа нь хахир хатуу өвлийн улирлуудад янз бүр байдаг. Улирлын хөлдөлтийн явцын дундаж гүн шаварлаг хөрсөнд 2.0

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨРГӨНИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ
10-Р ХҮДРИЙН БҮСИЙН ХЭСГИЙГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

м, элсэрхэг хөрсөнд 2.5 м, хайргархаг хөрсөнд 3.0 м хүрдэг байна. Хөлдөлтийн гүн нь хөрсний төрөл, найрлага, чийгийн агууламжаас хамааран янз бүр байх боловч ерөнхийдөө 3.0 м-ээс хэтэрдэггүй.



Зураг 6. Хөрсний тархалтын зураг

Ургамлан нөмрөгийн төлөв байдал: Дорноговь аймгийн Өргөн суманд байрлах Өргөний хайлуур жоншны 10-р хүдрийн бүсийн хэсгийг ил болон далд аргаар ашиглах төслийн талбай ургамал-газар зүйн мужлалын хувьд А.А.Юнатовын (1952) ангиллаар [13]: Евро Азийн хээрийн мужийн: Умард-Говийн цөлийн хээрийн провинцийн: Дорнод говийн цөлийн хээрийн тойрогт хамаарна. Дээрх хуваарилалт дээр үндэслэн 1989 онд Академич Н.Өлзийхутаг Монгол орны ургамалжлыг ургамал газар зүйн 16 тойрог болгон ангилсаны дагуу Дорноговийн цөлөрхөг хээрийн тойргийн баруун захад [10] оршиж байна.

Ургамлын амьдралын хэлбэр. Тус тусгай зөвшөөрлийн талбайд ургаж байгаа 24 зүйл ургамлын амьдралын хэлбэрээр ялгахад 8 зүйл нэг наст өвслөг ургамал (33.33%), 7 зүйл олон наст өвслөг ургамал (29.17%), мөн 9 зүйл сөөг, заримдаг сөөгөнцөр ургамал (37.50%) ургаж байна.

Монгол өвс-бударганат, монгол өвс-таана-бударганат болон таана-монгол өвст бүлгэмдэл бүхий тус талбай нь ургамлын зүйлийн бүтэц бүрэлдэхүүний баялагийн хувьд 100 м² талбайд 10-14 зүйл, 1м² талбайд 3 -8 зүйл бүртгэж, ургамалжлын хувьд ургамлын тусгагийн бүрхэц 38.2-39.8%, га-ийн биологийн ургац 1.366-1.734 цн байна.

Төсөл хэрэгжих талбай нь ургамал газарзүйн мужлалаар Евроазийн хээрийн мужийн дагуур Монголын хээрийн болон Умард-Говийн цөлийн хээрийн провинцын Дорноговийн цөлийн хээрийн тойргийн районд хамаарна.

Усзүйн сүлжээ: Тус төслийн талбай нь Монгол орны гадаргын усны сав газрын ангилалаар Галба Өөш-Долоодын голын ай сав газарт байрлана. Уг сав газар нь Газарзүйн мужлалаар сав газрын нутаг дэвсгэрийн ихэнх хэсэг буюу 96,6% нь манай орны хамгийн хур тунадас багатай, хуурай уур амьсгал бүхий говь, цөлийн бүсэд оршдог. Төслийн талбайн ойр орчимд гол мөрөн байхгүй.

Газрын доорх усны статик төвшин 27,2-57м –т тогтоогддог (ц-487, 393). Өрөмдлөгийн явцад ц-379, 473, 476, 565 –г хамарсан ямарч усжилтгүй бүс ялгардаг.

Газрын доорх ус нь химийн найрлагын хувьд сульфат-натри-кальцийн болон гидрокарбонат төрөлд багтах ба эрдэсжилт 1,6-2,0г/л, ерөнхий хатуулаг 5-5,6 мг/экв/л байна. Тэдгээрийн нөхөн сэргэх гол тэжээгдэл нь хур тундасны ус болон агаарын чийгийн конденсац болдог.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Лотус-Амгалан” ХХК-ийн Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт байрлах Өргөний хайлуур жоншны 10-р хүдрийн бүсийн хэсгийг ил болон далд аргаар ашиглах төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилсан байдлаар тодорхойлж гаргав.

Мөн төсөл үйл ажиллагааны улмаас байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Хүснэгт 10. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврын чанарын үнэлгээ

Нөлөөлөл		ҮР ДАГАВРЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ				
		НӨЛӨӨГҮЙ	БАГА	ДУНД	ИХ	АЮУЛТАЙ
Эерэг нөлөөлөл						
Хүмүүсийг ажлын байраар хангах таатай орчин нөхцөлийг нь бүрдүүлж ажиллуулж байгаа учраас сайнаар нөлөөлж эерэг нөлөөтэй байна.					LT	
Төслийн талбайн орчимд нөлөөлөлд өртөх амьтан					LT	
Сөрөг нөлөөлөл						
Агаар	Машины утаа тортог, автомашины хөдөлгөөнөөр тоос үүсэж агаарт дэгдэх			MT		
	Уурхайн олборлолт явагдаж шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх				LT	
	Төслийн үед том оврын машин, техник ашиглах бөгөөд яндангаас ялгарах хий агаар, орчныг бохирдуулна.			MT		
Хөрс бүрхэвч	Олон салаа зам гарган зорчих				LT	
	Машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох			ST		
Эрүүл мэнд	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасны хангалт, ашиглалтад анхааралтай хандаагүйгээс үйлдвэрлэлийн осолд өртөх			MT		
Ургамлан бүрхэвч	Олон машин техникийн хөдөлгөөнөөр орчны ургамлан бүрхэвч талхлагдах			MT		
	Тоосжилтын нөлөөтэй холбоотойгоор ургамалжилтын			ST		

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨРГӨНИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ
10-Р ХҮДРИЙН БҮСИЙН ХЭСГИЙГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

өсөлт хөгжилтөд сэргөөр нөлөөлөх				
Төслийн талбайн ургамлан нөмрөг устах			LT	

Тайлбар.

LT – урт хугацааны нөлөөлөл (10 жилээс дээш)

MT – дунд хугацааны нөлөөлөл (3-10 жил)

ST - богино хугацааны нөлөөлөл (3 хүртэл жил)

	шууд нөлөөлөл
	болзошгүй нөлөөлөл
	хам нөлөөлөл

Дээрх хүснэгтээс харахад тус төслийн үйл явцаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой нэг нь нөгөөдөө шууд буюу дам байдлаар нөлөөлөх нь харагдаж байна. Тус төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тооцоолсон дээрх матрицын аргаас үзэхэд төслийн үйл ажиллагааны явцад байгалийн төрх болон хөрс, биологийн төрөл зүйлд сөрөг нөлөөлөл үзүүлэх нь харагдаж байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /2025 ОН/

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан 2019 оны А/618 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг үндэслэл болголоо.

Байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх
- Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨРГӨНИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ
10-Р ХҮДРИЙН БҮСИЙН ХЭСГИЙГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал /2025 он/

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Жилийн зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан/	төгрөг	6,500,000
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	төгрөг	-
3	Тэрбум мод тарих төлөвлөгөөний зардал	төгрөг	1,320,000
4	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	17,500,000
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	-
6	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	-
7	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төгрөг	1,810,000
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	төгрөг	3,025,000
9	Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө	төгрөг	2,000,000
10	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	төгрөг	4,000,000
11	БОМТ -г орон нутагт тайлагнах	төгрөг	-
Дүн		төгрөг	37,155,000

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨРГӨНИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ 10-Р ХҮДРИЙН БҮСИЙН ХЭСГИЙГ ИЛ БОЛОН ДАЛД
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, төсөв, хэрэгжүүлэх хугацаа болон давтамжийг тусгаж өгөв.

Хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААР ОРЧИН						
1.	Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдэл	Цаг уурын урьдчилан сэргийлэх мэдээг үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Уурхайн бүхий л үйл ажиллагаанд	ҮАЗ-д тусгасан	Тогтмол	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2.	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Уурхайн дотоод, гадаад тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх, тоос дарагч бодис ашиглах	Уурхайн ашиглалтын талбайд	2,000.0	2025 онд	
3.		Салхи, шуурга ихтэй үед хөрс хуулах, ачиж тээвэрлэх үйл ажиллагааг хязгаарлах	Уурхайн ашиглалтын талбайд	---*--	Үйл ажиллагааны туршид	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.
4.		Тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох (40 км/цагаас хэтрэхгүй байх), тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засаж сайжруулах	Гадаад, дотоод тээврийн зам	1,000.0	2025 онд	Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
5.		Уурхайгаас дотоод гадаад тээврийн гол замын сүлжээ, маршрутыг тогтоох	Гадаад, дотоод тээврийн зам	500.0	2025 онд	
Дүн				3,500.0		
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ						
6.	Газрын гадарга эвдэрч, Хөрсний үржил шим алдагдах, бохирдох,	Техникийн эвдрэл гэмтлийг зориулалтын талбай (засварын цех)-д байрлуулж засах	Үйл ажиллагаа эхлэх үед, шинэ газар хөндөх бүрт	ҮАЗ-д тусгасан	2025 онд	Хөрс хамгаалах Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль Газрын тухай хуулийн 50.1.1
7.			Уурхайн хүрээнд	1 500.0	Тогтмол	MNS5914:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨРГӨНИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ 10-Р ХҮДРИЙН БҮСИЙН ХЭСГИЙГ ИЛ БОЛОН ДАЛД
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
8.	эвдрэх, доройтох	Засварын цех, ШТМ-ын агуулах, хуучин тос хадгалах цэг, ШТС зэргийн талбайг цементлэх				хуулалт, хадгалалт” MNS5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага”
9.		Хог хаягдлаар дамжин хөрсний бохирдол үүсгэхгүйн тул хог хаягдлын эцсийн цэгт хүргэх	Ахуйн хог хаягдлын цэг	Хог хаягдлын МТ-д тусгасан	2025	MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
10.		Машин техникийг маршрутын замаар явахыг хянах, зураг төслөөс гадуурх хөрс, талбайг хөндөхгүй байх	Үйл ажиллагааны турш	ҮАЗ-д тусгасан	2025	“Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал
11.		Замын усалгааг тоосжилт ихтэй үеүдэд хийж байх	Уурхайн дотоод, гадаад тээврийн зам	Агаарын чанарын хэсэгт тусгасгдсан	Хуурайшилт ихтэй үеүдэд	
12.	Ургамлан нөмрөг талхлагдахаас сэргийлэх	Ахуйн гаралтай шингэн хаягдлыг зориулалтын талбайд түр хадгалж био бэлдмэлээр тогтмол ариутгах, цаашид байгаль орчинд халгүй зайлуулах арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх	Уурхайн хог хаягдлын хүрээнд	Хог хаягдлын МТ-д тусгасан	2025 онд	
Дүн				1,500.0		
ГАЗРЫН ДООРХ УС						
13.	Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар усыг хэмжээгээр ашигласнаар усны нөөцөд	Унд ахуйн хэрэглээнд ашиглах усыг арвилан хэмнэх талаар ажилчдад сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчид	250.0	2025 онд	Усны тухай хууль: Зүйл 24-1.1, 1.2; Зүйл 30; Зүйл 31-1, 2, 3, 4, 5, 6, 8; Зүйл 33-1, 2, 3; Зүйл 34-1, 2; Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4596:1998. БОНБНҮ, Компанийн дотоод журам,
14.		Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах,	Усны хэрэглээгээр	ҮАЗ-д тусгасан	2025 онд	

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨРГӨНИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ 10-Р ХҮДРИЙН БҮСИЙН ХЭСГИЙГ ИЛ БОЛОН ДАЛД
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	сөргөөр нөлөөлөх					
15.	Газрын доорх ус	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах	Үйл ажиллагааны турш	1 250,0	2025	
16.		Бусад шаардлагагүй тохиолдолд гадаргын хэлбэр, төрх байдлыг өөрчлөхгүй байх		ҮАЗ-д тусгасан	2025	
Дүн				1 500,0		
АМЬТНЫ АЙМАГ						
20.	Малын бэлчээрийг доройтуулахаас сэргийлэх	Уурхайн тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх	Агаарын чанарын хэсэгт тусгасан	Агаарын чанарын хэсэгт тусгасан	2025 онд	Амьтны тухай хууль
21		Ахуйн гаралтай шингэн хаягдлыг зориулалтын талбайд түр хадгалж био бэлдмэлээр тогтмол ариутгах, цаашид байгаль орчинд халгүй зайлуулах арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх	Уурхайн хог хаягдлын хүрээнд	Хог хаягдлын МТ-д тусгасан	2025 онд	
Дүн				-		
НИЙТ				6.500,0		

4.2 Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө

Ордын нөхөн сэргээлтийг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008” стандартад нийцүүлэн БОНХАЖ-ын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэх ба нөхөн сэргээлтэнд шаардагдах зардлыг Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайдын хамтарсан 2010 оны 05 сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу тооцоолно.

Төслийн 1 дэх жил болох 2025 онд уул техникийн нөхцлөөр техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэх боломжгүй тул 2 дох жилээс хийгдэнэ.

4.3 Тэрбум мод тарих арга хэмжээний төлөвлөгөө

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нь Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт жилд 100 ш мод тариална.

100 ш суулгац худалдан авах 320.0 мян.төгрөг бөгөөд ногоон байгууламжийн арчилгаа тордолгоо, усалгаа, тариалалтын зардалд 1 сая.төг, нийт 1.32 сая.төгрөг зарцуулагдана.

4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Төслийн MV-013185 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлагатай асуудал байхгүй байна.

4.5 Түүх, соёлыг өвийг хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжих уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

4.6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11 -д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг. Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨРГӨНИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ 10-Р ХҮДРИЙН БҮСИЙН ХЭСГИЙГ ИЛ БОЛОН ДАЛД
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /сая.төг/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт аргачлал
1	Мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, дүгнэлтийг үндэслэн зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлэх	Орон нутгийн саналын дагуу	-	-	5.0	2025 онд	
2	Орон нутгаас авсан саналын дагуу дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэх	Орон нутгийн саналын дагуу	-	-	12.5	2025 онд	
Нийт дүн, сая.төг				17.5			

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨРГӨНИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ 10-Р ХҮДРИЙН БҮСИЙН ХЭСГИЙГ ИЛ БОЛОН ДАЛД
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

4.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 14. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Хээрийн түймэр уурхайн талбай, кемп рүү орж ирэх, уурхайн хээрийн түймэрт өртөх	Хээрийн түймрээс сэргийлж уурхайн талбайг тойруулан зурвас, далан байгуулах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр
Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаах дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах	Дотоод журам	2025 онд
	Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	560.0	2025 онд
	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр
	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр уурхай эхлэх үед
Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	-	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө
	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	250.0	Жил бүр, жилд 1 удаа
	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах	1,000.0	Жил бүрийн I улиралд байрлуулан сар бүр шалгаж байх
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах - Уурхайн талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Сөрөг нөлөөллийг бууруулах зардалд тусгасан	Жил бүр, жилд 1 удаа
Нийт зардал		1,810.0	

4.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйг ээс орчин бохирдох	Энгийн хог хаягдлын ангилан ялгадаг хогийн савыг тавих	Уурхайн хотхон	500.0	Төслийн эхэн үед	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах	1,000.0	Төсөл хэрэгжих хугацаанд	
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх	ШТС, Ажилчдын байр	700.0	Төслийн эхэн үед	
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш	500.0	Төслийн эхэн үед	Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж бүхий самбар, тэмдэгжүүлэлттэй болгох	Уурхайн ашиглалтын талбайд	325.0	Төслийн эхэн үед	
	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй тохижуулах	Зориулалтын хог хаягдлын цэг	ҮАЗ-д тусгасан	Төслийн эхэн үед	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
			3.025,0		

4.9 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Лотус-Амгалан” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчныг хамгаалан төлөвлөгөөтэй нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Лотус-Амгалан” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Лотус-Амгалан” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨРГӨНИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ 10-Р ХҮДРИЙН БҮСИЙН ХЭСГИЙГ ИЛ БОЛОН ДАЛД
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Хөрсний бохирдол						
1	Хөрсний агрохими хөрсний механик бүрэлдэхүүн	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, засварын газар, хогийн цэг орчимд	Жилд 1 удаа, 2-3 цэгт	350,0	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга,
2	Хөрсний хүнд металлын агууламж	Хөрс хүнд металлаар бохирдох, хөрс рүү нэвчих, гүний усыг бохирдуулах	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, засварын газар, хогийн цэг орчимд	Жилд 1 удаа, 2-3 цэгт	350,0	MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никелийг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3	Хөрсний эрүүл ахуй, микробиологи	Хөрсөөр дамжин гэдэсний халдварт өвчин, нянгийн өвчнөөр өвчлөх	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, засварын газар, хогийн цэг орчимд	Жилд 1 удаа, 2-3 цэгт	400,0	

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨРГӨНИЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ 10-Р ХҮДРИЙН БҮСИЙН ХЭСГИЙГ ИЛ БОЛОН ДАЛД
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
НИЙТ 1,100.0						
Усны хяналт шинжилгээ						
2.1	Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий шинжилгээ	Гүний худаг	Өөрсдийн гүний худаг	Жилд 1 удаа	450,0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
2.2	Усны чанар Микробиологи	Усны эрүүл ахуйн шинжилгээ		Жилд 1 удаа	450,0	MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
НИЙТ 900.0						
Ургамлын аймаг						
3.1	Ургамлын төрөл зүйл, бүрхэц, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамлын судалгаа	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө, шинэ газар хөндөгдөх болгонд,	Төслийн талбай	Жилд 1 удаа	2 000,0	Байгаль орчны мэргэжилтэн, ШУА Ботаникийн хүрээлэнтэй хамтарч ажиллах
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН					4,000.0 мян.төг	

4.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Тусгай зөвшөөрөлтэй талбай	Гэрээний үнийн дүнгээр	2025	Газрын тухай хуулийн 58.5
Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаарх сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах	Үйл ажиллагааны хүрээнд	1.0	2025	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ-д тусгасан	2025	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	Нийгмийн хариуцлагын хүрээнд	1.0	Төслийн хугацаанд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Нийт, сая.төг			2.0	

4.11 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч “Лотус-Амгалан” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ. Тус хэлэлцүүлгийг жил бүр 10-р сард зохион байгуулах ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд хэлэлцүүлгийн үр дүнг оруулна.

Хүснэгт 18. БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
БОУАӨЯ болон Дорноговь аймгийн Байгаль орчны газарт	Цахимаар	Тухайн жилийн БОМТ-ийн хэрэгжилтийн тайлан	11-р сар	-	-